



“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

АГУУЛГА

1. Мэдээлэл
2. Үнэлгээний зорилго
3. Үнэлгээний бүтэц, нэгдсэн дүн
4. Үнэлгээний аргачлал
5. Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан
6. Нотлох баримтын жагсаалт

Мэдээлэл:

“Гермес Центр” ХК-ийн зүгээс Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс” болон “Монголын Хөрөнгийн бирж”-ийн “Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал”-ын дагуу 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар өөрийн засаглалын хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээний тайланг танилцуулж байна.

Үнэлгээний зорилго:

Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс томилогдсон эрх бүхий албан тушаалтан хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

Үнэлгээний бүтэц, нэгдсэн дүн

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

“Гермес Центр” ХК-ийн 2025.06.30-ны өдрийн байдлаарх үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	Нэгдсэн дүн	72	72		100%

Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- ✓ Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- ✓ Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- ✓ Хэрэгжүүлээгүй, эсвэл үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- ✓ авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй
- ✓ 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх
- ✓ 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн
- ✓ 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай

НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааг үнэлсэн тайлан
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн ахисан түвшний гэрчилгээний хуулбарууд болон бусад
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл
4. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг баталсан ХЭХурлын тогтоол

НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	Бүрэн хэрэгждэг	Манай компани нь "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам" болон "ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журам"-д тэдгээрийн чиг үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан.	2	100%
2	Бүрэн хэрэгждэг	"ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам", "Компанийн залгамж халааны бодлого"-ын баримт бичигтэй.	2	100%
3	Бүрэн хэрэгждэг	Компанийн ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд нарийн бичгийн даргын жилийн ажлыг үнэлэх журам"-ыг 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан. Энэхүү журмын дагуу компани нь өөрийн үйл ажиллагааг анх удаа үнэллээ. Уг үнэлгээгээр манай компани 395 оноо авахаас 376 авч улмаар 95.1%-тай үнэлэгдсэн. <u>Хавсралтаар үг үнэлгээг хүргүүлэв.</u>	2	100%
4	Бүрэн хэрэгждэг	"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам", "ТУЗ-ийн дэргэдэх хороодын журам"-д тус шаардлагуудыг тусгасан байдаг. ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн тэнцвэрийн талаарх заалтыг 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд шинэчлэн оруулсан. Манай компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрээс 4 эрэгтэй, 5 эмэгтэй гишүүд байдаг.	2	100%
5	Бүрэн хэрэгждэг	Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ТУЗ-ийн гишүүдийг засаглалын ахисан түвшний мэргэшүүлэх сургалтанд хамруулахаар тусгасан. Энэхүү төлөвлөгөөний дагуу Компанийн Засаглалын Хөгжлийн төвтэй хамтран "Компанийн засаглалын хөгжлийн чиг хандлага ба байгууллагын соёл" сэдэвт сургалтыг 2025 оны 6-р сарын 12-ны өдөр зохион байгуулж ТУЗ-ийн гишүүдийг хамрууллаа. <u>Хавсралтаар ТУЗ-ийн гишүүдийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.</u>	2	100%

6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгждэг	"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам", "ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журам"-ын дагуу хариуцлага хүлээн ажилладаг.	2	100%												
Дүн				12	100%												
ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ																	
Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ																	
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгждэг	Компанийн ТУЗ-ийн гишүүд нь 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн ХЭХурлаар "Компанийн дүрэм"-д заасны дагуу 5 жилийн хугацаатайгаар сонгогдсон. Эдгээрийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2026 онд дуусгавар болох тул ХЭХурлаар компанийн ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, улмаар хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.	2	100%												
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгждэг	"Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны ажиллах журам", "Дотоод хяналтын заавар", "Эрсдэлийн удирдлагын заавар" зэрэг бодлогын баримт бичигтэй. Эрсдэл аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн болно. Хорооны хуралд гүйцэтгэх захирал болон ажилтнууд урилгаар оролцдог. <table><tr><td colspan="3">Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн</td></tr><tr><td>Дарга</td><td>Д.Туяа</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Н.Батсайхан</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Н.Мөнхзул</td><td>ТУЗ-ийн ердийн гишүүн</td></tr></table>	Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн			Дарга	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гишүүн	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гишүүн	Н.Мөнхзул	ТУЗ-ийн ердийн гишүүн	2	100%
Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн																	
Дарга	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн															
Гишүүн	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн															
Гишүүн	Н.Мөнхзул	ТУЗ-ийн ердийн гишүүн															
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь 3 гишүүнтэй бөгөөд хорооны үйл ажиллагааны журам болон цалин урамшууллын бодлоготой. Хорооны хуралд гүйцэтгэх захирал болон ажилтнууд урилгаар оролцож болно. Компанийн Цалин урамшууллын хорооны бүтэц бүрэлдэхүүнийг 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хараат бус гишүүдээр томилох асуудлыг хэлэлцэн, улмаар дараах байдлаар томилсон болно. Үүнд: <table><tr><td colspan="3">Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн</td></tr><tr><td>Дарга</td><td>Б.Алтангэрэл</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Д.Оюунсүрэн</td><td>ТУЗ-ийн ердийн гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Д.Туяа</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr></table>	Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн			Дарга	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гишүүн	Д.Оюунсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн	Гишүүн	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2	100%
Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн																	
Дарга	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн															
Гишүүн	Д.Оюунсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн															
Гишүүн	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн															

10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь 3 гишүүнтэй бөгөөд хорооны үйл ажиллагааны журам болон залгамж халааны бодлогын баримт бичигтэй. Хорооны хуралд гүйцэтгэх захирал болон ажилтнууд урилгаар оролцож болно. Нэр дэвшүүлэх хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хараат бус гишүүдээр томилох асуудлыг хэлэлцэн, улмаар дараах байдлаар томилсон. Үүнд: <table><tr><td colspan="3">Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн</td></tr><tr><td>Дарга</td><td>Н.Батсайхан</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Б.Алтангэрэл</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr><tr><td>Гишүүн</td><td>Б.Оюунцэцэг</td><td>ТУЗ-ийн ердийн гишүүн</td></tr></table>	Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн			Дарга	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гишүүн	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гишүүн	Б.Оюунцэцэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	2	100%
Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн																	
Дарга	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн															
Гишүүн	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн															
Гишүүн	Б.Оюунцэцэг	ТУЗ-ийн ердийн гишүүн															
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд компанийн засаглалыг хөгжүүлэх үүднээс шинээр хороо байгуулах боломжийг тусгасан заалт байдаг бөгөөд хороодын чиг үүргийг тодорхой заасан журам, бодлогын баримт бичигтэй.	2	100%												
Дүн				10	100%												
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ																	
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана																	
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгждэг	Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам болон Үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох журамтай бөгөөд журмын хэрэгжилтэнд ТУЗ хяналт тогтмол тавин ажилладаг. Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд компанийн ТУЗ болон ХЭХ, компанийн санхүү, үйл ажиллагаа, засаглалтай холбоотой мэдээллийг цаг тухай бүр нь өөрийн компанийн цахим хуудас, МХБиржийн цахим хуудсуудад нийтэлдэг.	2	100%												
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгждэг	Манай компани нь засаглалтай холбоотой батлагдсан дүрэм, журам, заавар болон бодлогын баримт бичгүүдийг тухай бүр өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудасны "Компанийн дотоод дүрэм, журам" хэсэгт байршуулан олон нийтэд тогтмол мэдээлдэг. https://www.hermescenter.mn/CorporateGovernance	2	100%												

14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгждэг	Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд үнэн зөв, ил тод дэлгэрэнгүй тайлагнадаг. Манай компани нь барилгын бизнес эрхлэгчдэд талбай түрээслэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хүрээлэн буй байгаль орчинд сөргөөр нөлөөлхүйц эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаггүй болно.	2	100%
----	--	-----------------	---	---	------

Дүн

6

100%

ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөдлөнгийн аудитортой харьцах, хөдлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэнд хяналт тавина.	Бүрэн хэрэгждэг	"ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны ажиллах журам"-д тусгасан бөгөөд хөдлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй хэрэгжүүлэх нөхцлөөр бүрэн хангадаг.	2	100%
----	--	-----------------	--	---	------

16	4.2. Хөдлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгждэг	Компанийн 2025 оны 4-р сарын 4-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд манай компанийн санхүүгийн тайланд хөдлөнгийн шалгалт хийдэг "Си Эс Ай Аудит" ХХК-ны аудитор Д.Чулуунбат, мөн компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Н.Батсайхан, хараат бус гишүүн Б.Алтангэрэл нар биечлэн оролцож, аудиттай холбоотой тайлан мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгсөн болно. Энэ тухай мэдээллийг ХЭ-ийн хурлын тэмдэглэлд тусган баталгаажуулсан. <u>Хавсралтаар аудитын компанийн албан тоот болон ХЭ-ийн хурлын тэмдэглэлийг хүргүүлэв.</u>	2	100%
----	---	-----------------	---	---	------

17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Бүрэн хэрэгждэг	Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг дараалсан хяналтын тогтолцоогоор хэрэгжүүлдэг бөгөөд "Дотоод хяналтын заавар"-г заагдсан хяналтын зарчмыг баримтлан ажилладаг.	2	100%
----	--	-----------------	---	---	------

Дүн

6

100%

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Бүрэн хэрэгждэг	Манай компани нь "Эрсдэлийн удирдлагын заавар"-ын бодлогын баримт бичгийг 2022.08.26-ны өдрийн хурлаар кодескт нийцүүлэн шинээр баталсан бөгөөд түүний хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавина. Компанийн эрсдэлийн удирдлагыг Эрсдэл аудитын хорооны гишүүд хариуцан ажилладаг.	2	100%
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгждэг	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хороо хариуцан ажилладаг. Компанийн санхүү болон үйл ажиллагаанд учирч болох аливаа эрсдэлийн талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-ийн хуралд танилцуулж, шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээг авч ажилладаг. Одоогоор манай худалдааны төвийн талбай бүрэн түрээслэгдсэн бөгөөд үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үйл ажиллагаанд нөлөөлөхүйц ноцтой эрсдэлтэй нөхцөл байдал үүсээгүй байгаа бөгөөд энэ талаарх мэдээллийг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж СЗХ болон МХБ-д цаасан хэлбэрээр хүргүүлсэн болно.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгждэг	Манай компани нь барилгын материал эрхлэгч, үйлдвэрлэгч нарт худалдааны талбай түрээсэлдэг. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон ХЭ-ийн хурлын материалд байгаль орчин, нийгмийн хариуцлагын талаарх тайлан мэдээллийг тусгаж олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Одоогоор компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц эрсдэлтэй нөхцөл байдал үүсээгүй байна.	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Бүрэн хэрэгждэг	Компани нь "Комплайнсын хяналтын заавар"-ыг ТУЗ-ийн 2022.08.26-ны өдрийн хурлаар баталсан. Байгууллагын ажиллах хүчний нөөц боломжинд тулгуурлан комплайнсын ажилтныг ТУЗ-ийн нарийн бичиг хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд хэрэгжилтэнд ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд манай компанийн засаглал болон үйл ажиллагаатай холбоотой санал гомдол оролцогч талуудаас ирээгүй болно.	2	100%
Дүн				8	100%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					

22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгждэг	Компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг ХЭХурлаар хэлэлцэн баталж, түүний гүйцэтгэлийг хувьцаа эзэмшигчдэд тогтмол тайлагнаж хэвшсэн бөгөөд ХЭ-ийн хурлын материал болон ХЭ-ийн хурлын тэмдэглэлд тусган баталгаажуулсан. Компанийн ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг баталсан тогтоолыг ХЭХурлын материалын хамт 2025 оны 4-р сарын 09-ний өдрийн 43 тоот албан бичгээр танай хороонд хүргүүлсэн болно. <u>Тогтоолын хуулбарыг хавсралтаар дахин хүргүүлэв.</u>	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Бүрэн хэрэгждэг	Манай компани нь хагас жил тутамд ажилтнуудыг "Ажилтны үнэлгээний хуудас"-аар үнэлж дүгнэдэг бөгөөд шалгуур үзүүлэлтийг цалин урамшууллын бодлогод бүрэн тусгасан.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгждэг	Компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн "Цалин урамшууллын мэдээлэл" хэсэгт тухайн жилд гүйцэтгэх захиралд олгосон цалин, урамшууллын хэмжээг тусгаж тайлагнадаг бөгөөд урамшуулал олгох шалгуурыг "Цалин урамшууллын бодлого" болон гүйцэтгэх захиралтай байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-гээр зохицуулдаг.	2	100%

Дүн

6

100%

ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн 2022.08.26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан "Компанийн ёс зүйн дүрэм"-д тусгасан.	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгждэг	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигч, харилцагч, олон нийт зэрэг бүхий л оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц агуулгаар бэлтгэн олон нийтэд мэдээлэн ажилладаг.	2	100%

27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгждэг	Компанийн www.hermescenter.mn болон МХБ-ийн www.mse.mn цахим хуудаснуудад компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг тогтмол байршуулан хувьцаа эзэмшигчид болон сонирхогч этгээдүүдийг мэдээллээр ханган ажилладаг.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгждэг	"Компанийн ажилтан ажиллагсдын ажлын байранд мөрдөж ажиллах хөдөлмөрийн дотоод журам" болон "Компанийн ажилтан ажиллагсдын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам"-д заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг. Тайлант хугацаанд оролцогч талуудын зүгээс санал гомдол ирүүлээгүй болно.	2	100%
Дүн				8	100%
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ					
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн 2022.08.26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан "Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулдаг.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн 2022.08.26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан "Компанийн комплайнсын хяналтын заавар"-аар шүгэл үлээгчийн тогтолцоог бүрдүүлсэн.	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгждэг	ТУЗ-ийн 2022.08.26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан "Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулдаг.	2	100%
Дүн				6	100%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгждэг	Жил, хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг зохицуулагч байгууллагаас баталсан маягтын дагуу бэлтгэж МХБ-ийн www.mse.mn , өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсуудад байршуулан олон нийтэд тогтмол хүргэдэг.	2	100%


33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгждэг	Компанийн 2024 оны 5-р сарын 29-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталж, улмаар өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Манай компани нь хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох зорилгоор өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудас болон МХБ-ийн www.mse.mn цахим хуудсуудад холбогдох мэдээллийг тогтмол шинэчлэн хүргэж байна. Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч холбогдох мэдээллийг тогтмол хүргүүлж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгждэг	Хувьцаа эзэмшигчдийг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрэн ханган ажиллаж байна.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгждэг	"Компанийн тухай хууль", "Компанийн дүрэм"-д заасны дагуу эрхээ хэрэгжүүлэх нөхцөл хангагдсан.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгждэг	"Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулагддаг бөгөөд ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийхийг ТУЗ-өөс бүрэн хориглосон байдаг. Тайлант хугацаанд буюу 2025 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.	2	100%
Дүн				10	100%
Нэгдсэн дүн				72	100%

Дүгнэлт

"Гермес Центр" ХК-ийн үнэлгээний нийт оноо 72 үнэлгээний хувь 100%-тай буюу засаглал хэвийн эрсдэлгүй гэж үнэлэгдсэн.



“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТУЗ-ИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ҮНЭЛСЭН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

1. Мэдээлэл
2. Үнэлгээний зорилго
3. Үнэлгээний бүтэц, нэгдсэн дүн
4. Дүгнэлт
5. Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан

Мэдээлэл: “Гермес Центр” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн 13-р тогтоолоор баталсан “Компанийн ТУЗ, түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааг дүгнэх журам”-ын дагуу компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний тайланг танилцуулж байна.

Үнэлгээг компанийн ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 12-ны өдрийн 6 тоот тогтоолоор батлагдсан үнэлгээний комисс нь 8 шалгуур үзүүлэлт, 79 асуулга бүхий маягтыг ашиглан үнэлсэн болно.

Үнэлгээний зорилго: Энэхүү үнэлгээний зорилго нь “Гермес Центр” ХК компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, компанийн засаглалын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, үр ашигтай технологи ашиглах, шинээр нэвтрүүлэх, ТУЗ-ийн гишүүдийн зан чанар болон тэдгээрийн мэдлэг, мэргэжил, ажлын туршлагыг нэмэгдүүлэх, тэдгээрт шаардлагатай сургалтын чиглэлийг тодорхойлох, цалин урамшууллыг ил тод үнэн зөвөөр тогтоох, урамшуулах механизмыг ил тод болгох, түүгээр дамжуулан үр ашигтай ажиллах хөшүүргийг бий болгоход оршино.

ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ, НЭГДСЭН ДҮН

№	Үзүүлэлт			Цаашид сайжруулах арга хэмжээ
		Авбал зохих оноо	Авсан оноо	
1	ТУЗ-ийн ерөнхий үйл ажиллагаа, бүрэн эрхийн хэрэгжилт	40	40	- ТУЗ-ийн гишүүдийг чадавхижуулах, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг зохион байгуулах
2	ТУЗ-ийн үйл ажиллагаа	65	64	- ТУЗ-д үүсэж болох аливаа эрсдэлийг урьдчилан тодорхойлох, улмаар түүнийг даван туулах арга замыг эрэлхийлэх
3	ТУЗ-ийн үүрэг, хариуцлага	25	20	- ТУЗ-ийн гишүүд нь аливаа эрсдэлтэй шийдвэр гаргасан тохиолдолд тэдгээрийг хамгаалсан хамгаалалтын арга механизмыг боловсруулах
4	ТУЗ-ийн дарга	60	60	- Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлж ажиллахад анхаарах
5	ТУЗ-ийн хороод	65	60	- ТУЗ-ийн дэргэд Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх, Эрсдэл аудитын хороо ажилладаг боловч эдгээр нь өөрсдийн хамаарах чиг үүргийн хүрээнд хангалттай хэмжээний санал зөвлөмжийг гаргах, ТУЗ-д шаардлагатай мэдээллийг танилцуулан

				үр ашигтай ажиллахад чиглүүлэх хэрэгтэй байна. - ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тогтоосон хугацаанд тогтмол хуралдаж байх, өөрсдийн чиг үүргийн хүрээнд тодорхой тайланг боловсруулан ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлж байх - Тайлангийн агуулгыг дэлгэрэнгүй, ойлгомжтой, тодорхой болгох
6	ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга	55	53	- ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг тогтмол хуралдуулж байх - Өөрсдийн хамаарах чиг үүргийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл өгөх, тайлан, санал, зөвлөмжийг боловсруулж байх
7	ТУЗ-ийн гишүүд	30	27	- Компанийн ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, туршлагыг дээшлүүлэх талаар бодлого боловсруулах
8	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	55	52	- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хууль эрхзүйн чиглэлийн сургууль төгсөөгүй тул цаашид хууль эрх зүй, компанийн засаглал, үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг боловсролоо дээшлүүлэх
Нийт оноо		395	376	

ДҮГНЭЛТ: Үнэлгээний үр дүнгийн хувьд 395 оноо авахаас 376 оноо авч 95.1 хувьтай үнэлэгдсэн. Үнэлгээний комисс нь ТУЗ-ийн цаашид анхаарч ажиллах, засаж сайжруулах чиглэлүүдийг тодорхойлсон бөгөөд шат дараатай хэрэгжүүлээд явбал үнэлгээний хувь нэмэгдэнэ гэж дүгнэлээ.



№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Компани болон түүний ХЭ-ийн сонирхлыг хамгаалахад ТУЗ үйл ажиллагаагаа хангалттай чиглүүлдэг байсан уу?					✓
2	ТУЗ шийдвэр гаргахдаа бизнесийн өртгийг нэмэгдүүлэх болон ХЭ-чдийн бусад сонирхлыг хангахад чиглэгдэж байсан уу ? Та үүнийг яаж үзэж байна?					✓
3	ТУЗ-ийн бүрэн эрх бодит байдал дээр ХЭХ болон Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхээс хэр ялгагдан зааглагдаж байсан вэ?					✓
4	Та ТУЗ-ийг өөрийн үүрэг, бүрэн эрх болон бусад гол зорилтуудаа бүрэн хэмжээнд ойлгон ажиллаж байгаа гэж үзэж байна уу?					✓
5	ТУЗ бүтэн жилийн туршид компанийн чухал асуудлуудыг шийдэхдээ компанийн үнэт зүйлс, алсын хараа, стратеги зорилтуудыг хэр ойлгож мэдэж байсан вэ?					✓
6	ТУЗ компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах болон түүний стратегийг тодорхойлох өөрийн үүргээ хэр үр ашигтай хэрэгжүүлж байна?					✓
7	ТУЗ компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тавих хяналтаа бололцоот хэрэгслүүд ашиглан хэрэгжүүлж чадаж байгаа юу?					✓
8	ТУЗ компанийн Гүйцэтгэх удирдлагын ажлыг дүгнэх өөрийн үүргээ хэр сайн хэрэгжүүлж байгаа вэ?					✓

Тайлбар: Цаашид ТУЗ-ийн гишүүдийг чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулах

ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний асуулга

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТУЗ чухал асуудлаа хэр зөв тодорхойлж чаддаг вэ?					✓
2	Та ТУЗ-ийн хуралд сайн бэлтгэхийн тулд хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг хангалттай цаг хугацаанд урьдчилан авдаг уу?					✓
3	Дээрх мэдээллийг хурлаас өмнө агуулга чанарын хувьд авч чаддаг уу?					✓
4	ТУЗ-ийн хурал хэлэлцэж буй асуудлаар гишүүд хоорондоо нээлттэй саналаа солилцон хэлэлцэж цаг тухайд нь шийдвэрээ гаргаж чаддаг уу?					✓
5	ТУЗ-ийн хуралд асуудал танилцуулагч шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл өгч чаддаг уу?					✓
6	Асуудал хэлэлцэх ба танилцуулах хугацааны хуваарилалт хэр зөв явагддаг вэ?					✓
7	ТУЗ-ийн хурлын зэрэгцээ компанийн ажилтан ажиллагсадтай мэдээлэл солилцох бололцоо байдаг уу?					✓
8	Гүйцэтгэх удирдлагын ажлыг дүгнэхийн тулд ТУЗ компанийн үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлдог уу?					✓
9	ТУЗ-ийн хурлын өмнө танд танилцуулсан санхүүгийн мэдээлэл нь компанийн чухал асуудал болон хэтийн чиглэлийг ойлгоход хангалттай мэдээлэл болдог уу?					✓
10	Танд өгч буй санхүүгийн мэдээллийн хэлбэр нь компанийн чухал асуудал ба хэтийн чиглэлийг салгасан байдаг уу?					✓
11	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлэх эрсдэлд анхаарлаа төвлөрүүлж ажилладаг гэж хэлж чадах уу?					✓
12	ТУЗ-д эрсдэлийг хянах систем байгаа юу?				✓	
13	Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн ажиллах журмыг танилцуулах мэдээлэл бий юу?					✓

Тайлбар: Цаашид ТУЗ-д үүсэж болох аливаа эрсдэлийг урьдчилан тодорхойлох, улмаар түүнийг даван туулах арга замыг эрэлхийлэх

ТУЗ-ийн үүрэг, хариуцлага

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Компанитай холбоотой асуудал үүсэхэд хүлээх үүргийн талаар мэдээлэл өгсөн үү, өгсөн бол хэр хангалттай байсан вэ?				✓	
2	ТУЗ-ийн гишүүдэд өөрийн хяналтын үүргийг гүйцэтгэхэд компанийн үйл ажиллагаа түүний онцлогийн талаар мэдэж авахад хангалттай хугацаа зарцуулсан уу?				✓	
3	ТУЗ-ийн гишүүдээс Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд өгч буй зөв шүүмжлэлийг хүлээн авч буй байдал хангалттай байдаг уу?					✓
4	ТУЗ-ийн гишүүд компанитай өөрийн хийсэн хэлэлцээр дэх сонирхлын талаар мэдээлдэг үү. Түүнийг хэлэлцэхэд санал өгөхөөс татгалдзаг уу?					✓
5	Таны хариуцлагын талаар компани хамгаалалтын ямар нэг хэлбэр илэрхийлдэг үү?		✓			

Тайлбар: Цаашид ТУЗ-ийн гишүүдийн зүгээс аливаа эрсдэлтэй шийдвэр гаргасан тохиолдолд тэдгээрийг хамгаалсан хамгаалалтын арга механизмыг боловсруулах

5. 10. 1997

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТУЗ-ийн хурлын үеэр гишүүдээс өөрсдийн санал бодлоо чөлөөтэй хэлж, нээлттэй хэлэлцүүлгийг дэмждэг байдал					✓
2	ТУЗ-ийн даргын үйл ажиллагаанд хангалттай цаг зарцуулдаг байдал					✓
3	Хурлаар хэлэлцэх асуудлыг зохих ёсоор санаачлан боловсруулдаг болон мэдээлдэг байдал					✓
4	Хурал эхлэхээс өмнө ТУЗ-ийн гишүүдэд хангалттай болон зохих ёсны материалуудыг илгээдэг эсэх?					✓
5	Хурлыг удирдан явуулах чадвартай эсэх?					✓
6	Хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад хурал даргалагчийн давуу байдал гаргадаг эсэх?					✓
7	ТУЗ-ийн шинэ гишүүдийн компанийн үйл ажиллагаатай танилцах, үйл ажиллагааг ойлгохыг дэмждэг эсэх?					✓
8	ТУЗ-ийн гишүүдийг санхүүгийн мэдээлэлтэй байх явдлыг хангадаг эсэх?					✓
9	Хурлуудын хооронд гишүүдтэй зохих ёсоор харилцдаг эсэх?					✓
10	ТУЗ-ийн шийдвэрүүд үр ашигтай байдлаар хэрэгжих байдлыг хангадаг эсэх?					✓
11	ТУЗ-ийн хурлын бусад үед гэсэн давуу байдал гаргаж, улмаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог эсэх?					✓
12	Гүйцэтгэх захирлын ажилд ТУЗ-ийн дарга гэсэн байдлаар оролцдог эсэх?					✓

Тайлбар: Компанийн засаглалын кодексыг бүрэн хэрэгжүүлэн ажиллахад анхаарах

ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлыг үнэлэх үнэлгээний хуудас

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТУЗ-ийн дэргэд шаардлагатай хороод ажилладаг уу?					✓
2	Хороод хэр үр ашигтай ажиллаж байна гэж үздэг вэ? Тэд шаардлагатай зөвлөмж өгч чаддаг уу?				✓	
3	Хорооны гишүүд тухайн хорооныхоо хариуцсан чиглэлээр хангалттай мэдлэг, чадвар туршлагатай юу?					✓
4	Хорооны гишүүн бус ТУЗ-ийн гишүүд хорооны шийдвэрийн талаар мэдээлэл хэр авдаг вэ?				✓	
5	ТУЗ-ийн дэргэд ажиллаж буй хороо нь компанийн өнөөгийн ажиллагаанд шаардлагатай эсэх?					✓
6	Хороо нь үйл ажиллагаандаа тодорхой зарчмыг баримтлан ажиллаж буй байдал					✓
7	Хороо нь өөрсдийн чиг үүргээ үр ашигтай хэрэгжүүлж буй байдал				✓	
8	Хороо нь чиг үүргээрээ дамжуулан ТУЗ-д шаардлагатай санал зөвлөмж гаргаж буй байдал				✓	
9	Хорооны гишүүд тухайн хорооныхоо хариуцсан чиглэлээр хангалттай мэдлэг, чадвар туршлагатай эсэх?				✓	
10	Хорооны гишүүн бус ТУЗ-ийн гишүүд хорооны шийдвэрийн талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ?					✓
11	Хорооны ажлын зохион байгуулалтын нэгдсэн болон хэвшсэн байдал					✓
12	Хороо өөрийн үйл ажиллагааг явуулахдаа дүрмээ баримтлан ажилладаг эсэх?					✓
13	Хорооны тайлангийн агуулга, хэлбэр бусдад ойлгомжтой байдал				✓	

Тайлбар: ТУЗ-ийн дэргэд Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх, Эрсдэл аудитын хороо ажилладаг боловч эдгээр нь өөрсдийн хамаарах чиг үүргийн хүрээнд хангалттай хэмжээний санал зөвлөмж гаргаж үр ашигтай ажиллах, мөн тайлангийн агуулыг ойлгомжтой, тодорхой болгох

ТУЗ-ийн дэргэдэх хороодын даргын ажлыг үнэлэх үнэлгээний хуудас

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Хорооны бүрэн эрх, ажиллах журмын дагуу хорооны үйл ажиллагааг удирдах чадвартай эсэх?					✓
2	Гишүүдээс хорооны хуралд өөрсдийн саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог хангадаг эсэх?					✓
3	Хорооны даргын үйл ажиллагаанд хангалттай цаг гаргадаг эсэх?					✓
4	Хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг зохих ёсоор тогтоодог эсэх?					✓
5	Хорооны хурлыг зохих журмын дагуу зарлах ажлыг зохион байгуулдаг эсэх?					✓
6	Хорооны хурлыг удирдан явуулах чадвартай эсэх?					✓
7	Хорооны хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал хураах үйл явцыг зөв удирдан зохион байгуулах чадвартай эсэх					✓
8	Хорооны хурлаас гаргасан шийдвэрийг агуулын хувьд ТУЗ-ийн хуралд танилцуулах ажлыг зөв удирдан зохион байгуулах чадвартай эсэх?					
9	Хорооны хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байдал				✓	
10	Хурлын чөлөөт цагт өөрийн санаачилгаар хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гишүүдтэйгээ харилцдаг эсэх?					✓
11	Хорооны чиг үүрэг, хамрах хүрээгээр дамжуулж компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог эсэх?				✓	

Тайлбар: Хорооны хурлыг тогтмол хуралдуулах, өөрийн хамаарах чиг үүргийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл өгөх

ТУЗ-ийн гишүүдийг үнэлэх үнэлгээний асуулга

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Гишүүдийн тоо хангалттай гэж үзэж байна уу?					✓
2	ТУЗ-ийн болон түүний хороодын удирдлага хэр үр ашигтай ажиллаж байна вэ?				✓	
3	ТУЗ-ийн гишүүдийн тоо, тэдний мэдлэг, туршлага болон бусад байх ёстой чанарын талаар боловсруулсан, хэрэгжүүлсэн, төлөвлөж буй бодлого байгаа юу?				✓	
4	Компанийн стратегийг боловсруулах болон үйл ажиллагаанд шаардлагатай хяналтыг хэрэгжүүлэхэд одоогийн ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг ур чадвар, ТУЗ-ийн бүтэц хангалттай юу?				✓	
5	ТУЗ-ийн гишүүдийн хамтын үйл ажиллагаа хэр үр ашигтай вэ? Тухайлбал ТУЗ хамтын байгууллагын хувьд хэр үр дүнтэй ажиллаж байна? Тодорхой чухал санал гаргасан гишүүнийг урамшуулдаг уу?					✓
6	ТУЗ-ийн хараат бус гишүүн бодит байдалд үнэхээр хараат бус байж чаддаг уу?					✓

Тайлбар: ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, туршлагыг дээшлүүлэх талаар бодлого боловсруулах

Нэмэлт тайлбар: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглал болон хууль эрхзүйн талаарх сургалтанд тогтмол хамрагдаж, мэргэжил мэдлэгээ дээшлүүлж байх нь манай компанийн засаглалын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байх болно.